

# ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2017 оны 12 сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

Тус хэлтэс нь 2017 онд улсын албан ёсны мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, графикт хугацаанд нь шуурхай нийлүүлэх, эдийн засгийн үзүүлэлтээр олон жилийн динамик судалгааны сан бүрдүүлэх, дүүргийн статистикийн эмхэтгэл, сар бүр нийгэм, эдийн засаг болон захиргааны статистикийн чиглэлээр танилцуулга гаргах, ажилчдын ажлын цаг ашиглалт, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэхэд онцгой анхаарч ажиллах зорилт дэвшүүлэн амжилттай хэрэгжүүлж байна.

## **1. СТАТИСТИКИЙН МЭДЭЭ ТАЙЛАН:**

1.1. 2017 онд мэргэжилтэн нэг бүрээр ажил үүргийн хуваарь, ажил орлон гүйцэтгэх хуваарь, танилцуулга хариуцан гаргах хуваарийг гарган Албан ёсны статистикийн мэдээлэлд сар, улирал, жилийн давтамжтайгаар өссөн дүнгээр 8000 гариу аж ахуй нэгж байгууллагыг мэдээнд хамруулж, графикт хугацаанд мэдээллээ.

1.2 Сар бүр дүүргийн хэлтэс албадын мэдээлэл болон захиргааны статистик мэдээллээр нийгэм эдийн засгийн танилцуулга гаргаж, Нийслэлийн статистикийн газар болон дүүргийн цахим хуудсанд тогтмол байршуулж байна.

1.3 Мал тэжээвэр амьтны тооллогыг амжилттай зохион байгуулж 1337 толгой мал, 763 тэжээвэр амьтан тус тус тоологдсон. Уг судалгаанд үндэслэж мал тэжээвэр амьтан, хөдөө аж ахуйн судалгааг хийж, тархаав.

1.4 Салбар бүрийн статистикийн танилцуулгуудын тоо мэдээллийг нэгтгэн боловсруулан гаргасан

1.5 Статистикийн 2016 оны эмхэтгэлийг дүүргийн хэлтэс албадын мэдээлэл, албан ёсны статистик болон захиргааны мэдээллээр баяжуулан, нэгтгэн гаргасан.

1.6 Бизнес регистрийн сангийн чанарыг сайжруулж, эхний 2 улирлын байдлаар 379 аж ахуйн нэгжийг нэмж баяжилтыг хийсэн. Жилийн эцсийн мэдээний хүрээний тодруулга худалдааны 6167, барьцаалан зээлдүүлэхийн 425, аялал жуулчлалын 394 ААНБ-ын мэдээлэл тус тус ирсэнийг хугацаанд нь хийж онлайн программд шивж дамжуулав.

## **ХОЁР: СТАТИСТИКИЙН ТООЛЛОГО, СУДАЛГАА:**

2.1 2017 оны 5 дугаар сарын 22-ноос 6 дугаар сарын 15-нд улс даяар зохион байгуулагдсан Эрчим хүчний дансыг байгуулснаар эрчим хүчний нөөц, ашиглалтыг эрчим хүчний бүтээгдэхүүний төрлөөр хянах, эрчим хүчний багтаамж, түүний үр ашиг, бүтээмжийн үзүүлэлтүүдийг тооцох судалгааг Чингэлтэй дүүргийн 138 аж ахуй нэгжээс авсан. Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын судалгааг 6 нэгжийн 90 өрх сонгогдож, судалгааны багийг хороодын Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагчдад мэдээлэл өгч, судалгааг бүрэн дуусгасан

2.2 Мал тэжээвэр амьтны тооллогыг амжилттай зохион байгуулж 1337 толгой мал, 763 тэжээвэр амьтан тус тус тоологдсон. Уг судалгаанд үндэслэж мал тэжээвэр амьтан, хөдөө аж ахуйн судалгааг хийж, тархаав.

2.3 Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар бүх нийтийн зөвлөлдөх санал асуулга 2017 оны 04 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд явагдаж, Чингэлтэй дүүргээс 46 хүн сонгогдсоноос 40 хүн урилга авч 04 дүгээр сарын 29-ний өдөр 36 хүн, 2 дахь өдөр 34 хүн хамрагдав.

2.4 Эмэгтэйчүүдийн эрүүд мэнд, амьдралын туршлага судалгааны хүрээнд манай дүүргээс 13-н хорооны 13-н хэсэгт түүвэрчилсэн судалгаа явуулах өрхийн жагсаалтыг маягтын дагуу тодруулга авч НСГ-ийн мэргэжилтэнд илгээсэн.

2.5 Статистикийн мэдээллийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх, өөрийн үйл ажиллагааг сурталчилах зорилгоор албан ёсны статистик болон захиргааны мэдээллийг нэгтгэн боловсруулж дүүргийн нийгэм, эдийн засгийн байдлын тухай статистикийн танилцуулгыг сар, улирлаар гарган аж ахуйн нэгж байгууллага болон холбогдох хүмүүст цаасаар хүргүүлдэг ба Нийслэлийн Статистикийн хэлтсийн [www.ubstat.mn](http://www.ubstat.mn) сайт болон дүүргийн [www.chingeltei.gov.mn](http://www.chingeltei.gov.mn) вэб хуудсанд тогтмол байршуулан ажиллаж байна.

2.6 Байгаль орчны судалгаанд нийт 108 ААНБ түүвэрлэгдэн ирж судалгаанд хамрагдсан.

2.7 Тээврийн аж ахуй нэгж байгууллагуудын тээвэрлэсэн бүтээгдэхүүний, үйлдвэрлэгчийн үнийн судалгааг 6 ААНБ-с авсан.

2.8 Чингэлтэй дүүрэг тооны хэлээр 2017 оны боршур гаргасан.

2.9 Чингэлтэй дүүргийн товч танилцуулга хэвлэн гаргав.

2.10 7 хоног бүрийн үнийн танилцуулга хэвлэн гаргасан.

2.11 Хөрөнгө оруулалтын судалгаа 2016 оны 4-р улирал, 2017 оны 1-р улиралд-15 ААНБ-аас авч программд шивэв.

2.12 Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө, хөрөнгө оруулалтын улирлын мэдээг 2017 оны 1 дүгээр улиралд 45 аж ахуйн нэгж, байгууллагаас авч програмд шивсэн. 2017 оны 2 дугаар улиралын мэдээг 1 хүнд 12-13 ААНБ оногдохоор хэлтсийн мэргэжилтэнгүүдэд тэнцүү хуваарилалт хийсэн. 2017 оны 2,3 лугаар улиралд 13 аж ахуйн нэгж, байгууллагаас мэдээг авч, графикт хугацанд шивж мэдээлэсэн

2.13 Нийнмийн даатгал, орон сууцны судалгааг сүүлийн 5 жилийн байдлаар холбогдох мэдээллийг цуглуулж дүүргийн хэмжээнд нэгтгэж гаргав.

### **ГУРАВ: СТАТИСТИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, БОДЛОГЫН ЗӨВЛӨГӨӨ**

3.1 Дүүргийн нийгэм, эдийн засгийн танилцуулгыг дүүргийн хэлтэс албад, захиргааны болон албан ёсны статистик мэдээллийг оруулан сар бүр эмхэтгэн нэгтгэж Нийслэлийн статистик газар, Дүүргийн цахим хуудсанд тогтмол байршуулж, иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангаж байна

3.2 Статистикийн хэлтсээс үзүүлж буй төрийн үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгааг хийж статистик мэдээллийг иргэдэд ойлгомжтой байлгарын тулд гаргадаг эмхэтгэл, тацилцуулгын загварыг шинэчлэн ажиллаж байна

3.3 Анхан шатны бүртгэл хөтлөлтийг сайжруулах ажлын хүрээнд хороодын статистик хариуцсан ажилтнуудад бүртгэл хөтлөлт, алдаа, цаашид анхаарах асуудал зэргээр Үндэсний статистикийн хороотой хамтран сургалтын амжилттай зохион байгуулав.

3.4 ББО1- мэдээний 2016 оны жилийн эцсийн программын тоо мэдээллийг үндэслэн Барилгын салбарын 2016 оны танилцуулгыг гаргаж [ubstat.mn](http://ubstat.mn) цахим хуудсанд байршуулсан..

3.5 Мал төллөлт, төл бойжилтын мэдээг мал бүхий 3 хорооноос нэгтгэн авч ХАА-1 маягтаар 2017 оны 4-6 сарын 4-нд графикт хугацаанд онлайн програмд шивж мэдээлсэн.

3.6 Жимс, жимсгэний талбай, хураасан ургацын мэдээ /ХАА-5/-г 1 сарын 4-нд 5 хороодоос 186 өрхийн мэдээллийг нэгтгэн авч, шалган графикт хугацаанд онлайн программд шивж мэдээлсэн.

3.7 Тариалсан талбайн талбайн мэдээг 7-19 дүгээр хороодоос нэгтгэн авч 5,6-р сард графикт хугацаанд онлайн програмд шивж мэдээлсэн.

3.8 Мал эмнэлэгийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагын 2016 оны жилийн эцэс болон 2017 оны 1 дүгээр улирлын мэдээг МЭ-1 маягтаар 2

аж ахуйн нэгж байгууллагаас хүлээн авч, хянаж боловсруулан графикт хугацаанд нь шивж мэдээлсэн.

3.9 Худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын жилийн мэдээ ААНБ-1, ААНБ-2 маягтаар, Хүрээгээр нийт ААНБ -1 маягтаар-105 ААНБ-2 маягтаар-198

Үүнээс: Мэдээнд хамрагдсан: ААНБ-1 маягтаар-100

- Шалтгаантай: ААНБ-1 маягтаар-5
- Мэдээнд хамрагдсан: ААНБ-2 маягтаар-192
- Шалтгаантай: ААНБ-2 маягтаар-4 байгууллагыг тус тус мэдээнд хамруулж холбогдох тодруулгыг тухай бүрд нь хугацаанд нь хийж явуулав.Үүнд: нийт 43 аага-ын ББӨ,БО-ыг тодруулж, 58 аанб-ын орлогыг сангийн яамны орлоготой тулгаж, 89 аанб-ын сангийн яамны цалинтай харьцуулж засвар хийв.

3.10 Худалдааны салбарын үнийн мэдээлэлийг 2015 оны үнийн мэдээлэлд суурилж 2016 оны 1-12 сар,2017 оны эхний 3 сарын байдлаар 11 аж ахуйн нэгж байгууллагаас 6768 нэрийн барааг бараа материалын журналаас нь түүж нэгтгэн нэр төрлөөр нь мэдээллийг цуглуулж 4,5-р сард excel файл бэлтгэж ҮСХ-ны мэргэжилтэн Элбэгсайханд явуулав.Мөн Бишрэлт интернешнл ХХК-ний 28000 нэрийн барааны мэдээллийг файлаар нь ҮСХ-ны мэргэжилтэн Н. Мөнхцэцэгт хүлээлгэж өгөв.

#### **ДӨРӨВ: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА**

4.1 Хэлтсийн даргын зүгээс ажилтан бүр дээр мэдээ тайлангийн ирцийн бүртгэл, мэдээний дамжуулалт зэргийг цаг минутаар хөтөлж бүртгэн хянаж ажиллаж байна.

4.2 Хэлтсийн ажилтан албан хаагчдын харилцааны соёл, мэндлэх, хүндлэх соёлыг бий болгож хэвшүүлэх мэдээлэгч байгууллагуудтайгаа хүндэлж харилцах зарчмыг барин ажиллаж байна.

4.3 Ажилтан албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг бүрдүүлж ажиллахад анхаарч, ногоон ажлын байрыг бий болгохоор ажиллаж байна.

4.4 Хороодын Эрүүл аюулгүй байдлын индексийн тоон мэдээллийн үнэн бодит байдал болон маягтын уялдаа холбоог шалгах нийслэлийн ажлын хэсэгтэй хамтран ажиллав.

4.5 Бүх нийтийн мод тарих өдрийн үеээр 19-р цэцэрлэгт өмнөх жил тарьсан шар хуайс, хайлаас зэрэг мод, бутгаа арчлан усалж, цэцгийн мандал тарьж, арчлалт хамгаалалтанд нь байнга анхаарал тавин хамтран ажиллаж байна.

4.6 Төрийн албаны зөвлөлөөс баталсан, журам зааврын дагуу “Хүний нөөцийн бүртгэл, хувийн хэрэг”-ийг хүн бүр дээр хөтөлж, баяжилтыг байнга хийж ажиллаж байна.

4.7 Дүүргийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулдаг иргэдийн баяр, мод тарих, Чингэлтэй дүүрэг байгуулагдсаны 25 жилийн ойн баярын хүрээнд зохион байгуулагсан иргэдийн баяр болон бусад арга хэмжээнд хамт олноороо идэвхтэй хамтран ажиллав.

ТАЙЛАН БИЧСЭН:  
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ

М.ТҮВШИНТӨР